136

ОРХОН АЙМАГ

# ЖАРГАЛАНТ СУМЫН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН ТОГТООЛ

2025 оны 12 сарын 18 өдөр Дугаар 02/26 Жаргалант сум

Соёлыг дэмжих хөтөлбөрийг хэрэгжүүлэх
2026 оны төлөвлөгөө батлах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 35 дугаар зүйлийн 35.1.18 дахь заалт, 48 дугаар зүйлийн 48.1 дэх хэсэг, 49 дүгээр зүйлийн 49.1 дэх хэсэг, Соёлын тухай хуулийн 23 дугаар зүйлийн 23.1.1 дэх хэсгийг тус тус үндэслэн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2025 оны 12 дугаар сарын 18-ны өдрийн ээлжит IV хуралдаанаас ТОГТООХ нь:

1.Соёлыг дэмжих хөтөлбөрийг хэрэгжүүлэх 2026 оны төлөвлөгөөг хавсралтаар баталсугай.

2.Хөтөлбөрийн хэрэгжилтийг ханган, төлөвлөгөөний биелэлтийг 2026 оны 4 дүгээр улиралд багтаан тайлагнахыг Засаг дарга (Л.Учрал)-д даалгасугай.

ДАРГА Ш.БИЛГҮҮНБААТАР

61250100

Сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2025 оны
12 дугаар сарын 18-ны өдрийн ээлжит IV
хуралдааны 09/26 тогтоолын хавсралт

**СОЁЛЫГ ДЭМЖИХ ХӨТӨЛБӨРИЙН 2026 ОНД ХЭРЭГЖҮҮЛЭХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ**

2025.12.18 Жаргалант сум

| № | Хөтөлбөрийн зорилт | Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ | Шалгуур үзүүлэлт | Хэмжих нэгж | Үр дүнгийн үзүүлэлт | | | Санхүүжилт | | Хариуцан хэрэгжүүлэгч |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | Суурь он | Суурь түвшин | Зорилтот түвшин (2026 он) | Санхүүжилт мян.төг | Санхүүжилтийн эх үүсвэрийн ангилал | |
| 1 | **Зорилт 1:** Иргэд, олон нийт, хүүхдэд чиглэсэн сургалт зохион байгуулах<br><br>*/Монгол улсын Ерөнхийлөгчийн зарлиг 2024 оны 02 сарын 01 өдөр Дугаар 09/ /Соёлын* | Морин хуурын сургалтад сумын иргэдийг хамруулах | Хамрагдсан хүний тоо | Тоо | 2025 | - | 5 | 4,500.0 | ОНХС | ИТХ, ЗДТГ, СМТ |
| 2 | | Амьд хөгжмийн сургалтад сумын иргэдийг хамруулах | Хамрагдсан хүний тоо | Тоо | 2025 | - | 8 | 12,000.0 | ОНХС | ИТХ, ЗДТГ, СМТ |
| 3 | | Ерөөлч магтаалч, морь бөхийн цол дуудах сургалтад сумын | Хамрагдсан хүний тоо | Тоо | 2025 | - | 5 | 6,500.0 | ОНХС | ИТХ, ЗДТГ, |

138

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | *тухай хуулийн 11-р зүйл, 16.1.2, 21.1.11, 23.1, дахь заалтууд/* | иргэдийг хамруулах | | | | | | | СМТ |
| | | Секц дугуйлан хичээллүүлэх | Хамрагдсан хүний тоо | Тоо | 2025 | 135 | 140 | - | Үйл ажиллагааны зардал | СМТ |
| 4 | Соёлын өвийг нээж илрүүлэх, хадгалах, хамгаалах, үйл ажиллагааг эрчимжүүлэх *“Алсын хараа-2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогын 1.5.1, Монгол Улсын 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэлийн 1.5.1, "Соёлын өвийг хамгаалах* | Үл хөдлөх түүх дурсгалт газруудын байршлыг тогтоох хаягжуулах, насжилтыг тогтоолгох төсвийг судлах, соёлын биет болон биет бус өвийг нээж илрүүлэх,хадгалж хамгаалах | Тоо ширхэг | Тоо | 2025 | 298 | 315 | - | Үйл ажиллагааны зардал | СМТ |

139

| | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | *тухай хуулийн 37.4, Монгол Улсын Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөр/* | | | | | | | | | |
| 6 | **Зорилт 2:** Байгууллагын тохижилтыг сайжруулж, шаардлагатай тоног төхөөрөмжөөр хангах | Давхар тайзны арын 2 давхар руу гарах зориулалтын шат болон Г хэлбэрийн хаалт хийх | Ажлын гүйцэтгэл | Хувь | 2025 | - | 100 | 3,220.0 | ОНХС | ИТХ, ЗДТГ, СМТ |
| 7 | | Баяр ёслолын үед хэрэглэх шаардлагатай хивс, тугны суурь, аудио индэртэй болох | Барааны тоо ширхэг | Тоо | 2025 | - | Суурь 6ш, хивс 1ш аудио индэр 1ш | 5,000.0 | ОНХС | ИТХ, ЗДТГ, СМТ |
| 8 | | Цахилгааны тасралтгүй байдлыг хангах мотортой болох | Барааны тоо ширхэг | Тоо | 2025 | - | 1ш | 5,000.0 | ОНХС | ИТХ, ЗДТГ, СМТ |
| **Нийт төсөв: 36,220.0 төгрөг** | | | | | | | | | | |

140